



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 0/31

Арвайхээр

Нэг өдрийн цалин хандивлах аян,  
санаачилгыг өрнүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоол, аймгийн ИТХурлын Тэргүүлэгчдийн "Баяр наадам зохион байгуулах бүрэлдэхүүн батлах тухай" 2017 оны 13 дугаар тогтоол, сумын ИТХурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр хот үүсгэн байгуулагдсаны 290 жилийн ойн хүрээнд хийх бүтээн байгуулалтын ажилд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд нэг өдрийн цалингаа хандивлах аян, санаачилгыг өрнүүлсүгэй.

2. Нэг өдрийн цалингаа хандивлах аян, санаачилгыг дэмжиж, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, хотын Захирагчийн алба, багийн Засаг дарга нарын албаны нийт албан хаагчдын нэг өдрийн цалинг хандивлах ажлыг 2017 оны 03 дугаар сард багтаан хэрэгжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга /В.Шоовдор/, Нягтлан бодогч /М.Отгон/ нарт даалгасугай.

3. Цалингийн хандивын орлогыг бүтээн байгуулалтын ажилд нэр заан хөрөнгө оруулалт хийж, тухайн байгууллага, хамт олонд тайлагнахыг ойн зохион байгуулах комиссын төсөв, санхүүгийн салбар ажлын хэсгийн гишүүн, сумын ЗДТГазрын Санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч /Ц.Пүрэвсүрэн/, хотын Захирагчийн албаны менежер /Ц.Төмөрбаатар/-д нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

14 0061